

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

2022



Компанийн нийгмийн хариуцлагын бодлого,
Соёлын өвийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн
Сентрал тв | Энержи Ресурс
“Монгол өв соёл” нэвтрүүлгийн бүтээлүүдээс...



I. КОМПАНИЙН ТУХАЙ	1
II. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	1
III. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	2
IV. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	4
V. ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА	6
VI. АЖИЛЛАГСАД	12
VII. БАЙГАЛЬ ОРЧИН	14
VIII. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	18
IX. ШАГНАЛ	20

I. КОМПАНИЙН ТУХАЙ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

Энержи Ресурс компани нь 2005 онд байгуулагдсан үндэсний уул уурхайн компани бөгөөд 2009 оноос хойш Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар шууд ба шууд бусаар нийт 5,000 орчим хүнийг ажлын байраар хангахын зэрэгцээ үндэсний 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй урт хугацаанд хамтран ажиллаж ирлээ. Мөн татвар төлөлт, нийгмийн хариуцлагаар Монгол Улсын ТОП 5 компанийн жагсаалтанд сүүлийн арав гаруй жил тасралтгүй бичигдэж байна.

2010 онд Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцааны хяналтын багцыг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Бид олборлолт, баяжуулалт, тээвэр, экспортыг цогцоор шийдсэн, дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уурхайн үйл ажиллагаа эхэлсэн цагаас Ухаа худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Төвөөс 560 км алслагдмал говийн суманд Нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, ус хангамжийн систем, 650 айлын орон сууц, 1,000 гаруй хүүхдийн багтаамжтай сургууль, цэцэрлэгийн цогцолбор зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж байгуулахдаа шаардлагатай боловсон хүчнийг сургаж бэлтгэх, сум орон нутагтай

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.

байнгын эргэх холбоотой хамтын ажиллагаа хөгжүүлэх бүхий л боломжуудыг бүрдүүлж ажилласан.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Гашуунсухайт боомтод Чингэлэгт тээврийн терминалыг 2021 онд барьж ашиглалтанд оруулснаар нүүрсний экспорт эрчимжиж, хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварт тодорхой ахиц гарсан байна.

Бид нээлттэй хувьцаат компани гэдэг утгаараа компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ыг анхнаас нь бодитой, зөв хэрэгжүүлэхэд анхаарч бодлого чиглэлээ олон улсын КНХ-ын сайн дурын стандарт ISO:26000-д нийцүүлэн боловсруулсан.

Мөн Монголын уул уурхайн салбарт анх удаа Чанарын удирдлага (ISO 9001:2015), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага (HSAS 18001:2007), Байгаль орчны удирдлага (ISO 14001:2015) олон улсын стандартуудаар Менежментийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Уг тогтолцоог нэвтрүүлснээр үйл ажиллагааны бүхий л үе шатанд мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй сайжруулан олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.

Нийгмийн хариуцлага, байгаль орчин, нөхөн сэргээлтийн бодлого болон орон нутгийн тогтвортой хөгжилд оруулах бидний хувь нэмэр компанийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй салшгүй холбоотой байдаг.

II. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА


НҮБ-аас дэлхий дахинаа тунхагласан “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилсан, тогтвортой хөгжилд хүрэх урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Уг баримт бичгийн нийт 17 зорилго, 169 зорилтыг хэрэгжүүлэхэд олон улсын болон төр, төрийн бус, хувийн хэвшил, олон нийт зэрэг бүхий л оролцогч талуудын идэвхи санаачлага, хамтын оролцоо нэн чухал гэж тодорхойлсон байдаг.

Манай орны хувьд Алсын хараа- 2050 Тогтвортой хөгжлийн чиг хандлагыг Монгол Улсын урт хугацааны бодлого хөтөлбөртэй уялдуулсан бичиг баримтыг голлон мөрддөг.

Энержи Ресурс компани нь олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулж, тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Энэ дагуу 2011 онд Тогтвортой хөгжлийн бодлого, 2012 онд Компанийн нийгмийн хариуцлагын бодлогоо боловсруулан баталж, үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хэрэгжүүлэн ажилласаар ирсэн. Бид компанийн байгаль орчин, нийгэм, засаглалын бүхий л үзүүлэлт, үйл ажиллагаагаа Тогтвортой хөгжлийн 17 зорилтод нийцүүлж, нягт уялдуулах зарчмыг баримталж, уг санаачлагыг дэмжин ажиллаж байна. Цаашид байгаль орчин, нийгэм, засаглалын үзүүлэлтүүд, тэдгээрт хамааралтай эрсдлүүдийг нарийн тодорхойлохын хэрээр Тогтвортой хөгжлийн зорилтуудад харгалзах үр дүнгийн үзүүлэлтүүд нарийвчлагдан гарах юм.



III. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Энержи Ресурс компани нь олон улсын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани гэдэг утгаараа компанийн засаглалыг байгууллагын хөгжлийн чухал үзэл баримтлал гэж үздэг бөгөөд хувь нийлүүлэгчид ба бүхий л оролцогч талуудын эрх ашиг, тэдгээртэй адил тэгш харьцах зарчим болон мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлд онцгой анхаарал хандуулж ирсэн.

Бид компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, нүүрсний салбарт улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж үздэг.

Иймд тус компани нь дотоодын болон олон улсын хэмжээнд мөрдөгддөг, сайн засаглалын шаардлагуудыг биелүүлэн ажилладаг төдийгүй нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтын энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэхүйц байдлаар дотоодын дүрэм, журмуудынхаа хэрэгжилтийг ханган ажилладаг.

Компанийн хувь нийлүүлэгчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) болон гүйцэтгэх удирдлага нь Компанийн эрхэм зорилго, алсын хараа, эрхэм зүйлс, зорилтуудад компанийн сайн засаглалын олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, компанийн засаглалын соёлыг байгууллагууныхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөх талаар тусгаж баталгаажуулсан байдаг. Компани нь ТУЗ-д үйл ажиллагаагаа шууд тайлагнадаг Дотоод аудитын хэлтэстэйгээс гадна компанийн ерөнхий менежмент, хөрөнгийн удирдлага, шийдвэр гаргалтын үйл явц, тэдгээрийн үр дүнг хянан удирдах чиг үүрэг бүхий Аудитын хороо ТУЗ-ийн дэргэд ажиллаж байна. Одоогоор тус хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн, хараат бус 3 гишүүн ажилладаг.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ХОРОО

Компани нь Байгаль орчин, нийгэм, засаглалын гүйцэтгэлийн хэмжилт, хяналт, тайлагналд өндөр ач холбогдол өгөн ажиллаж ирлээ. 2019 онд компанийн ТУЗ-ийн дэргэд Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал хариуцсан, бие даасан хороо байгуулагдсан бөгөөд ингэснээр КНХ, байгаль орчин, засаглалын бодлого, стратеги чиглэлүүд, тухайн оны холбогдох үзүүлэлт, үр дүнгүүд ТУЗ-ийн түвшинд хянагдан, батлагдаж байна. Мөн КНХ-ын чиглэлд аливаа эрсдэл, алдаа дутагдал үүссэн тохиолдолд ТУЗ-өөс санал зөвлөмж өгөх, ахиц сайжралт гаргах, байнгын эргэх холбоотой хяналт тавих боломж бүрдэж байна. Түүнчлэн 2022 онд Гүйцэтгэх захирлаар ахлуулсан Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлаар дагнасан Удирдлагын хороо байгуулагдаж, холбогдох ажил мэргэжил, чиг үүргийн 9 гишүүнтэйгээр ажиллаж

байна. Тус хороо нь Байгаль орчин, нийгэм, засаглалын гол хэмжүүр үзүүлэлтүүд, зорилтууд болон үйл ажиллагааны ба урт хугацааны болзошгүй эрсдлүүд ба шинэ боломжуудыг тодорхойлж, компанийн менежмент, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, компанийн ТУЗ-ийг холбогдох мэдээ, мэдээлэл, чиг үүргээр ханган ажиллахаар зорилтоо тодорхойлсон. Ингэснээр компани нь Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлыг компанийн өдөр тутмын үйл ажиллагаа ба урт хугацааны төлөвлөлтөд тусгахаас гадна гүйцэтгэлийн үр өгөөжийг тогтмол сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм.

ТУЗ-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал хариуцсан хороо нь Удирдлагын хорооны үйл ажиллагааг ерөнхий чиг үүргээр ханган ажиллаж байна.

ИЛ ТОД БАЙДАЛ

Бид олон улсын "ISO 26000: Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөмж" болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн бодлого болон Компанийн Нийгмийн Хариуцлагын бодлогоо 2011 онд боловсруулан батлуулж, компанийн бүх салбар болон охин компаниудад танилцуулан, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсээр ирлээ.

Түүнчлэн оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон төр засаг, оролцогч талууд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн.

2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга

(ОУИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна. Мөн Монголын уул уурхайн ассоциаци, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран санаачилсан "Хариуцлагаар нэгд" аян, "Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс"-д нэгдсэнээр холбогдох үүрэг, амлалтаа бодитоор хэрэгжүүлэн ажиллаж байна. Компанийн холбогдох тайлангууд, шинэ мэдээ мэдээлэл болон ажлын байртай холбоотой бүхий л мэдээллүүд компанийн албан ёсны вэб хуудас (www.energyresources.mn; www.mmc.mn) болон нийгмийн сүлжээний хаягуудаар тогтмол нийтлэгдэж явдаг. Мөн бид оролцогч талууд, орон нутгийн иргэдээс Өргөдөл, гомдол нээлттэй хүлээн авах механизмтай бөгөөд, тухайн жилд хүлээн авсан өргөдөл, санал хүсэлтүүдийн тоо ба хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх мэдээллийг холбогдох тайлан, мэдээнд тогтмол тусгадаг.

ЁС ЗҮЙ, ХҮНИЙ ЭРХ

Бид хүний эрхийн үндсэн зарчмуудыг байгууллагын соёлын үндсэн хэсэг болгон төлөвшүүлснээс гадна үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутгийн иргэдийн болон ажиллагсдынхаа эрхийг зөрчихгүй байх талаар анхаарч хүний эрхийн эрсдлийн үнэлгээ хийж, хөтөлбөр боловсруулан ажилладаг. Тухайлбал, Ухаа худаг төслийн хүрээнд шинээр орсон ажилтнуудад компанийн Ёс зүйн код, хүний эрхийн журмыг заавал танилцуулахаас гадна жил бүр бүх ажиллагсдыг хүний эрхийн сургалтад давтан хамруулдаг.

Компанийн Ёс зүйн код нь ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авилгал хээл хахууль зэрэг зүйл зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсдад өгч буй удирдамж, зааварчилгаа болдог. Энэхүү Ёс зүйн кодын хүрээнд ажиллагсад болон бусад оролцогч талууд бизнесийн ёс зүйн өндөр стандартыг баримтлан ажиллаж бүхий л төрлийн зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх улмаар шаардлагатай тохиолдолд таслан зогсоохыг эрмэлздэг.

Бид үйл ажиллагааныхаа аль ч үе шатанд, түүнчлэн уурхай, төв офис ба дагалдах дэд бүтцийн аль ч бүрэлдэхүүн хэсэгт насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулах, албадан хөдөлмөрлүүлэх эсвэл хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгт ашиглахыг үл тэвчих бодлого баримталдаг бөгөөд энэ чиглэл дэх Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг чанд мөрдөн ажилладаг. Тус компани нь 2016 онд батлагдсан Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийг чанд мөрдөхөөс гадна 1990, 2002 онд соёрхон баталсан Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 2002 онд соёрхон баталсан Хөдөлмөрийн насны доод хэмжээг тогтоох тухай конвенц зэрэг холбогдох бусад баримт бичиг, хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажилладаг.



АВИЛГААС АНГИД БАЙХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компанийн холбогдох бодлого, дотоод дүрэм, журмуудад авилга хээл хахуулиас ангид байж, шийдвэр гаргахад албан тушаалтанд нөлөөлөх, давуу байдал бий болгох, шан харамж олгохоос зайлсхийх, бүх төрлийн бизнесийн харилцаанд авилга, хээл хахууль авахыг хориглох тухай тодорхой заасан. Үүнд, компанийн Ёсзүйн код, Хөдөлмөрийн дотоод журам, Зөрчлийг мэдээлэх, хариуцлага тооцох тухай журам, “Шүгэл үлээх”, зөрчил мэдээлэх бодлого болон хангамж, худалдан авалттай холбоотой бүхий л дүрэм, журмууд багтана. Эдгээр бодлого, журмууд нь зөвхөн компанийн дотоодод бус, манай үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын түвшинд хүрч үйлчилдэг. Бид бүхий л оролцогч талуудтайгаа нягт хамтран ажиллах замаар авлигын эсрэг үйл ажиллагаа болон нийгмийн хариуцлагатай ханган нийлүүлэлтийн сүлжээний туршлагыг хэрэгжүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

Манай худалдан авалт болон худалдан авалтын үйл ажиллагааны бүхий л үе шатанд шударга бус бизнесийн хэлцэл, сэжигтэй төлбөр болон терроризм, мөнгө угаахтай холбоотой санхүүжилтийг эрс хориглодог. Бид Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Авилгын эсрэг хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудыг даган мөрдсөөр ирсэн. Цаашлаад, ханган нийлүүлэгч ба туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүд нь Энержи Ресурс компанийн холбогдох бодлого, дүрэм журамд нийцсэн, авилга хээл хахуулиас ангид үйл ажиллагаа явуулдаг эсэх, хүний эрхийн ба хөдөлмөрийн эрхийн зөрчил гаргадаггүй байх зэргийг бодлого, журмуудынхаа хүрээнд хянан, мөрдүүлж ажилладаг.

IV. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

 **+50** (2009-2022)

Нийгмийн хариуцлагын төсөл, хөтөлбөрүүд

 **347** тэрбум (2021: 132 тэрбум)

Татвар, шимтгэл

 **5,000** (2021: 2,500)

Шууд ба шууд бус ажлын байр

 **~2,000**

Урт хугацаанд хамтарч буй дотоодын ААН-үүд

Энержи Ресурс компанийн хувьд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Энэ утгаараа Олон Улсын Стандартын Байгууллагаас 2010 онд гаргасан ISO 26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн Тогтвортой хөгжлийн болон КНХ-ын бодлогоо боловсруулж, үйл ажиллагаандаа тусгаж ирсэн.

Уг бодлогын зорилт нь ирээдүй хойч үеийн хэрэгцээг хангах байгалийн нөөц, боломжийг аль болох доройтуулахгүй байхын зэрэгцээ байгаль орчин, орон нутгийн иргэдэд сөрөг нөлөөллийг ямагт тооцож, хариуцлагатай, урт хугацааны тогтвортой бизнесийн зарчмаар ажиллахад чиглэдэг.

Компанийн зүгээс хийж хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хийж төслийн сонирхогч талууд болон олон нийтэд танилцуулдаг. Энэхүү үнэлгээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжүүлэлтийн явцад эерэг нөлөөллийг дэмжин, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах төлөвлөгөөний дагуу тодорхой шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн.

- Төслийн сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө
- Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх төлөвлөгөө
- Байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөө
- Өргөдөл гомдол барагдуулах механизм
- Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө
- Олон нийтийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын төлөвлөгөө
- Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө



Эдгээр төлөвлөгөөний дагуу хийсэн ажлуудаа хөрөнгө оруулагч болон олон нийтэд тогтмол тайлагнах үүрэг хүлээдэг. Энэ дагуу бид 2008 оноос буюу Ухаа худаг уурхайн үйл ажиллагаа хараахан эхлээгүй байх үеэс эхлэн орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, ил тод хэлэлцэх Нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг тогтмол хийж ирсэн. Өнгөрсөн 2022 онд “Хариуцлагатай уул уурхайд иргэдийн оролцоо” сэдэвт нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Ханхонгор, Цогтцэций сумдад, орон нутгийн нийт 700 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулсан.

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд төслийн үндсэн үйл ажиллагаа хэрэгждэг тул орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн суурь бүтцүүдийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг.

Ингэхдээ нэг удаагийн хандив тусламжаар асуудлыг шийдэх бус, үлдэцтэй, олон хүнд бодитой үр өгөөжөө өгч чадахуйц, урт хугацааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар орон нутгийн цаашдын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах үндсэн зарчмыг баримталж ирлээ.

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР


Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлснээс хойш татвар төлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн хэмжээгээр Монгол Улсын ТОП 5 аж ахуйн нэгжээр тогтмол шалгарч, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулсаар ирсэн.

2009 онд үүсэн байгуулагдсан цагаасаа хойш компани нийт нэг 1.4 тэрбум орчим долларыг уурхайн болон дагалдах дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан төдийгүй улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 1.7 их наяд орчим төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энержи Ресурс компани тайлант хугацаанд буюу 2022 онд нийт 347 тэрбум төгрөгийг улсад татвар, шимтгэл хэлбэрээр төвлөрүүлжээ.

Бид үйл ажиллагааныхаа хүрээнд дотоодын нийт 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн байна. Зөвхөн 2022 оны байдлаар бид нийт 470 гаруй аж ахуйн нэгжээс нэг их наяд орчим төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авсны 80-аас дээш хувь нь дотоодын аж ахуйн нэгж, компаниуд байлаа. Мөн тайлант онд бид ажиллагсдын цалин урамшуулалд нийт 96 тэрбум төгрөгийг олгосон байна.

ТАТВАР ХУРААМЖ




НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг мөрдлөг болгож, хүний эрхийг дээдлэх, оролцогч, сонирхогч талуудын идэвхтэй оролцоог хангах, шударга, нээлттэй, ил тод байх зарчмуудыг баримтлан ажиллахыг эрмэлздэг.

Тайлант онд нийгмийн хариуцлагын чиглэлийн хандив тусламж, хөрөнгө оруулалтад нийт 28 орчим тэрбум төгрөгийг зарцуулжээ. Бид 2022 онд нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын үйлсэд бодит хувь нэмрээ оруулах төсөл хөтөлбөр болон ивээн тэтгэлгийн хүрээнд “Говийн уурхайчид”, “Цэцийн өнгө”, “Дэлхийг хэрсэн соёлын өртөө”, “Илгээлтийн багш”, “Ашигт малтмал баяжуулагчдын холбоо”, “Уул уурхайн эрдэнэс зөвлөл”, “Зогсолтгүй өөдөө”, “Шаравын Сүрэнжав сан”, “Монголын манлайлал менежментийн холбоо” зэрэг нийгэмд болон гишүүддээ үйлчилдэг 20 гаруй ТББ-уудтай үндэсний хэмжээнд хамтарч ажилласан байна.

НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ



САГСАН БӨМБӨГИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГУУДЫН АЛБАН ЁСНЫ ТҮНШ

Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд Энержи Ресурс компани сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багуудын албан ёсны түншээр гуравдахь жилдээ нэрлэгдэн “Энержи 3х3 сагсан бөмбөгийн клуб” ТББ, “3х3 сагсан бөмбөгийн холбоо”, “Монголын сагсан бөмбөгийн холбоо” зэрэг ТББ-уудтай нягт хамтран ажиллаж байна.

Тухайлбал, Монголдоо анх удаа “Энержи 3х3” мэргэжлийн клубыг байгуулан, шигшээ багуудын байнгын бэлтгэл сургуулилт, бүс нутаг, тив дэлхийн тэмцээнүүд болон Олимпын наадамд оролцох бүх боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тус клубт мэргэжлийн нийт долоон баг харьяалагддаг. Хамгийн чухал нь, багийн спортоор шинэ залуу тамирчид төрөн гарах, гадаад, дотоодод өрсөлдөх боломжийг өргөжүүлж өгч буйгаараа ач холбогдолтой юм.

2022 онд мэргэжлийн нийт долоон багийн 30 тамирчинд санхүүгийн болон бэлтгэл, сургуулилт, менежментийн байнгын дэмжлэгийг үзүүлэн ажиллажээ. Тайлант онд цар тахлын дараах хориг хязгаарлалтууд бүрэн дуусаагүй, тодорхой хүндрэлүүд байсан хэдий ч бид тамирчдынхаа тэтгэлгийг тасралтгүй олгосноос гадна FIBA 3х3-ийн World Tour, Challenger, Women's Series, Super Quest зэрэг гадаад болон дотоодод зохион байгуулагдсан олон улсын 20 гаруй тэмцээнд амжилттай оролцож, “Ulaanbaatar MMC Energy” баг нь чансаагаараа дэлхийн шилдэг 8 багийн нэгт шалгарсан бодит үр дүн үзүүлсэн юм. Мөн Монголын 5х5 сагсан бөмбөгийн Үндэсний лиг, Сагсан бөмбөгийн Азийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан шатны тэмцээнүүдийг эх орондоо амжилттай зохион байгуулахад албан ёсоор түншилж, олон улсад өрсөлдөх чадамжгүйгээр багагүй хугацааг өнгөрүүлээд байсан үндэсний шигшээ багуудаа чадавхижуулж, шинэ шат ахиулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

V. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бид үүсэн байгуулагдсан цагаасаа хойш орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг төсөл хэрэгжилтийн явцад тусгаж ирсэн бөгөөд жил бүр хамгийн багадаа нэг тэрбум гаруй төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулсаар ирсэн.

Энержи Ресурс компани нь төслийн үйл ажиллагаандаа оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн урт хугацаанд тогтвортойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу дараах зарчмуудыг ханган ажилладаг.

- Иргэд, олон нийтийг компанийн үйл ажиллагааны талаар холбогдох мэдээлэл авах эрхийг бүхий л талаар ханган ажиллах;
- Олон нийтийн иргэдийн санал хүсэлтийг “Нээлттэй өдөрлөг” хийх замаар үйл ажиллагаандаа тогтмол тусгах;
- Орон нутгийн иргэдийн оролцоог хангах замаар төрөл бүрийн хэлэлцүүлэг, бүлгийн уулзалт, сайн дурын зөвлөлийг дэмжин ажиллах;
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад

- чиглэсэн зорилтот төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- Иргэдийн санал, хүсэлт болон өргөдөл гомдлыг мэдээллийн төв болон бусад сувгаар тогтмол хүлээн авах

Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл (ОНЗ)-ийг байгуулан тууштай хамтран ажилласаар ирсэн.

Бид оролцогч талуудтайгаа орон нутгийн мэдээллийн төв болон бусад сувгаар дамжуулан хамтран ажиллаж, иргэдийн ажилд орох хүсэлтийг хүлээн авахаас гадна тогтмол хугацаанд нөлөөллийн бүсийн иргэдтэй биечлэн уулзаж, малчдын гэрээр орж санал, гомдлыг нь сонсдог.

Түүнчлэн орон нутгийн иргэдийг байгаль орчны мониторинг, гар худаг болон тоосны хэмжилт, нөхөн сэргээлтийн ажилд сайн дураараа хяналт тавих байдлаар тогтмол оролцуулдаг нь компани ба иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлдөг.

21.3 тэрбум
(2021: 9.5 тэрбум)

**Орон нутгийн
хөрөнгө оруулалт**

39%
(2021: 40 %)

**Орон нутгийн
ажиллагсад**

1.7 тэрбум
(2021: 1.3 тэрбум)

**Орон нутгийн
хандив тусламж**



ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Бид орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, ялангуяа дэд бүтэц, иргэдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг зорьж ажилласаар ирсэн.

Энэ хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дүгээр заалт болон Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан загвар гэрээний хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар болон Энержи Ресурс компани хооронд хамтын ажиллагааны гэрээг 2017 онд байгуулсан юм.

Хамтын ажиллагааны гэрээний дагуу орон нутгийн онцлог, хөгжлийн бодлоготой уялдуулан олон нийтэд хүртээмжтэй, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх ажлыг оролцогч талуудтайгаа хамтран үр дүнтэй хэрэгжүүлэх зарчмыг баримталсан.

Ийнхүү орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих урт хугацааны хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоотойгоор арав гаруй жил үр дүнтэйгээр хэрэгжүүлж байгаа нь энэхүү гэрээний үндсэн зарчим бөгөөд хэрэгжилт, үр дүнг жил тутам Өмнөговь аймгийн Засаг дарга болон Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнаж, ОУИТБС-ын тайланд тусгасаар ирсэн.

2022 онд зохиогдсон нээлттэй өдөрлөгийн үеэр орон нутгийн удирдлагуудаас гаргасан санал хүсэлтийг хүлээн авч, Өмнөговь аймгийн Ханхонгор сумтай байгуулсан хамтран ажиллах гэрээгээ шинэчиллээ.



ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙД ИРГЭДИЙН ОРОЛЦОО - НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ 2022

Энержи Ресурс компани нь оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний дагуу иргэдтэй нүүр тулж уулзан, мэдээлэл түгээх, иргэд, олон нийтийн санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах зорилго бүхий нээлттэй өдөрлөг, олон нийтийн хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Ковид-19 цар тахлын жилүүдэд түр хугацаанд завсарласны дараа буюу 2022 онд “Хариуцлагатай уул уурхайд иргэдийн оролцоо” сэдэвт нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг Цогт-Овоо, Ханхонгор, Цогтцэций сумдад, орон нутгийн нийт 700 гаруй иргэдийг хамруулан амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр компанийн ба уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны менежмент, орон нутагт оруулж буй нийгмийн хөрөнгө оруулалт, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн талаар иргэдэд мэдээлэл өгч, асуудлуудыг ил тод хэлэлцэн, тэдний сонирхсон асуултанд хариулж, санал солилцсон.

Мөн санал асуулга, өргөдөл гомдлын хуудас болон нээлттэй ажлын байрны анкетуудыг хүлээн авлаа. Тус компаниас сүүлийн арав гаруй жилийн хугацаанд хэрэгжүүлж буй нийгмийн хариуцлагын төсөл, хөтөлбөрүүд нь орон нутгийн тогтвортой хөгжилд багагүй хувь нэмэр оруулж буйг цөөнгүй хүмүүс онцолжээ.



ОНЦЛОХ КЭЙС

Ханхонгор сумын малчин И.Оюун: “Энержи Ресурс компанийн мэргэжилтнүүд манай сумын төв дээр Нээлттэй өдөрлөг хийж, өргөн хүрээтэй хэлэлцүүлэг явууллаа. Би зорьж ирж оролцон гол нөлөөллийн бүс болох Хондот баг руугаа илүү төвлөрч, хамтарч ажиллах боломжийн талаар өөрийн санал бодлоо илэрхийллээ. Мөн манай сумтай Хамтын ажиллагааны гэрээний дагуу ажиллаж, орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан нийгмийн хариуцлагын зөндөө ажлууд хийсэн талаар тоо баримт сайтай, үнэн зөв мэдээлэл авлаа. Зарим үйл ажиллагаанд нь хамрагдаж л байсан. Орон нутгийн удирдлагуудын зүгээс энэ гэрээгээ шинэчилж сайжруулах санал тавьж байгааг дэмжиж байна”

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

Орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэн эргэн мэдээлэх “Иргэд, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлэн ажилладаг. Ингэхдээ өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар ханддаг.

2022 онд 8 төрлийн нийт 44 өргөдөл хүсэлт, нэг гомдол хүлээн авч, хүсэлтүүдийг 100 хувь шийдвэрлэсэн байна. Эдгээрээс 39 өргөдлийг дэмжиж, 6 өргөдөлд татгалзсан хариу өгчээ. Өргөдлүүдэд компаниас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, сургалтад хамрагдах дадлага хийх, хамтран ажиллах мөн санхүүгийн болон биет дэмжлэг хүссэн, утгатай хүсэлтүүд зонхилж байсан. Сийрст багийн иргэнээс ирүүлсэн автобусны буудлыг шилжүүлэх гомдлын тухайд автобус үйлчилгээний “Шүүт трейд” ХХК-тай холбогдож, өөр тийш нь шилжүүлснээр гомдлыг бүрэн барагдуулсан. Компанийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бодитой хэрэгжүүлж, нээлттэй, олон талт харилцааг хөгжүүлэн ажиллаж ирсний үр дүнд сүүлийн жилүүдэд иргэдийн шаардлага, гомдлын тоо багасч, харин хамтын ажиллагааны санал хүсэлтийн тоо эрс нэмэгдэж байна.

ОРОН НУТГИЙН САЙН ДУРЫН ЗӨВЛӨЛ

Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс 2011 оноос хойш Ханбогд, Баян-Овоо, Цогтцэций сумдад 9-11 хүний бүрэлдэхүүнтэй, ОНЗ-ийг байгуулах санаачилгыг гаргаж сумдын ИТХ-аар бүрэлдэхүүнийг батлуулан хамтран ажилласаар ирсэн. ОНЗ нь компанийн төлөөлөлтэй хамгийн тогтмол хугацаанд уулзаж, нутгийн иргэдийн санал зөвлөмжийг уламжилж, компани болон иргэдийн хооронд нээлттэй, эрх тэгш оролцоог хангах, хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлж байна.

Цогтцэций сум дахь ОНЗ нь нийгмийн олон талын бүлгийн төлөөллөөс бүрдсэн есөн гишүүнтэй бөгөөд 2022 онд хоёр удаа хуралджээ. Хурлаас компанийн үйл ажиллагааг орон нутгийн иргэд оролцогч талууд хүлээн зөвшөөрдөг болсон тул цаашид хамтын ажиллагаанд төвлөрч, зорилтот төсөл, үйл ажиллагаанд илүү анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн санал дүгнэлтийг ирүүлсэн. Энэ дагуу ОНЗ-тэй хамтран сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд ногоон дэлхий, экологийн боловсрол туршлага, мэдлэг олгох нөлөөллийн төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Орон нутгийн тогтвортой хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш төвөөс 560 км алслагдсан бүс болох Өмнөговь аймгийн Цогтцэций сум буюу Ухаа худагийн хөндийд өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн. Тухайлбал, Монгол инженерүүдийн ур ухаанаар дулааны цахилгаан станц, усан хангамжийн систем барьж байгуулснаар орон нутгийн иргэд 24 цагийн найдвартай эрчим хүч, ундны

цэвэршүүлсэн усаар хангагдах болсон.

Мөн 650 айлын, орон сууцны “Цэций” хороолол, сургууль цэцэрлэгийн “Мөрөөдөл” цогцолборыг барьж байгуулснаар ажиллагсад болон орон нутгийн иргэд ая тухтай амьдрах, хүүхэд багачууд говийн алслагдмал суманд ч тохилог орчинд, чанартай боловсрол олж авах нөхцөл боломж бүрдсэн. Тайлант онд нийт 21.3 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр болон орон нутгийн худалдан авалт, хандив тусламжид зарцуулсан байна.

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2022		төгрөг
I. Орон нутгийн дэд бүтэц		3,329,200,000
Ус хангамж		2,123,200,000
Ус цэвэршүүлэх байгууламж		1,206,000,000
II. Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд		1,984,700,000
Боловсролыг дэмжих хөтөлбөр		37,500,000
Байгаль орчныг дэмжих хөтөлбөр		1,572,300,000
Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр		16,500,000
Соёлын өвийг дэмжих хөтөлбөр		358,400,000
III. Хандив, тусламж (Өмнөговь)		1,716,792,000
Хандив		534,000,000
Орон нутгийн ТББ-уудын хамтын ажиллагаа		96,000,000
Нүүрсний дэмжлэг		913,792,000
“Сайн хөрш” хөтөлбөр		173,000,000
IV. Орон нутгийн худалдан авалт		14,300,000,000
V. НИЙТ		21,330,692,000

ОРОН НУТГИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах явдал байдаг. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчдэд аль болох онцгойлон анхаарч, хамтран ажиллахыг нэн тэргүүнд зорьдог. Энержи Ресурс компани нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд дотоодын нийт 2,000 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн байна. 2022 оны хувьд бид нийт 470 гаруй аж ахуйн нэгжээс нэг их наяд орчим төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авсаны 80-аас дээш хувь нь дотоодын аж ахуйн нэгж, компаниуд байлаа.

Өмнөговь аймгийн хэмжээнд мөн онд орон нутгийн 24 аж ахуйн нэгжээс нийт 14.3 тэрбум төгрөгийн худалдан

авалт хийсэн нь өнгөрөгч оныхоос даруй гурав дахин өссөн үзүүлэлт болжээ.

Манай нийт ажиллагсдын 40 орчим хувь нь орон нутгийн иргэд байдаг тул ажиллагсдын цалин урамшуулал, нийгмийн хангамжаар дамжин сум орон нутгийн эдийн засагт томоохон нөлөөтэй байдаг. Тухайлбал, зөвхөн орон нутгийн ажиллагсдын цалингийн хэмжээ 30 орчим тэрбум төгрөг байна.

Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төсөл, хөтөлбөрөө тогтвортойгоор үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүгүй зээл олгосоор байна. Уг хөтөлбөрийн хүрээнд сүүлийн арван жилийн хугацаанд Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо сумдын жижиг, дунд бизнес эрхлэгч 80 орчим иргэнд нийт 600 гаруй сая төгрөгийн зээл олгожээ.



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компаниас нийгэм, орон нутагт чиглэсэн, урт хугацааны үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрүүдийг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлсээр ирсэн. Үүсэн байгуулагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэлх арав гаруй жилийн хугацаанд:

- Орон нутгийн боловсролыг дэмжих
- Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
- Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
- Соёлын өвийг хамгаалах
- Ажлын байрыг нэмэгдүүлэх
- Байгаль орчныг хамгаалах

гэсэн үндсэн чиглэлүүдээр нийгмийн хариуцлагын нийт 50 гаруй бие даасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирлээ.

Тайлант онд орон нутгийн засаг захиргаа, малчид, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтайгаа хамтран орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, уламжлалт ажлуудыг үргэлжлүүлж, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг ханган ажиллалаа.

Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд компанийн орон нутагт оруулсан бүхий л хөрөнгө оруулалт нь тус бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, цаашлаад орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд болон компанид үр өгөөжөө өгөх зорилго агуулагдаж байдаг. Компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй нийт төсөл, хөтөлбөрүүдэд шууд байдлаар 10,000 орчим хүн хамрагдаж байна.



Орон нутгийн боловсролын хүртээмжийг дэмжих хөтөлбөр

Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг 2013 оноос хойш үе шаттай хэрэгжүүлж, 2019 оноос эхлэн шинэчилсэн хэлбэрээр үргэлжлүүлж байна. Цогтцэций сумын ерөнхий боловсролын хоёр сургуулийн нийт 2,000 гаруй сурагчийг хамардаг уг хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатараас чадварлаг багш, зөвлөхүүдийг Цогтцэцийд гэрээгээр ажиллуулах, хүүхэд бүрт хүртээмжтэй математикийн онлайн хөтөлбөр нэвтрүүлэх, багш нарт гүйцэтгэл, үр дүнгийн урамшуулал олгох зэрэг ажлууд хийгдэж ирсэн.

Тайлант онд “Сураад” математикийн онлайн програмд дээрхи сургуулиудын 5-11-р ангийн 555 сурагчийг хамруулан сурагчдын математикийн хичээлийн хоцрогдол арилгах, чанарыг сайжруулахад анхаарч ажиллалаа. Мөн сургалтын чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд “Мөрөөдөл” сургуулийн нийт эцэг эхчүүдээс сургалтын чанар сургуулийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгааг авсан.

Орон нутгийн сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжид мөн анхаарч, Цогтцэций сумын долдугаар цэцэрлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 520 кв талбайтай иж бүрэн тохижуулсан байрыг зургаа дахь жилдээ үнэ төлбөргүй ашиглуулснаар 140 хүүхдийг цэцэрлэгт хамрагдах боломжийг бүрдүүлсэн. Тайлант онд тус цэцэрлэгийн бүх бүлгийн хүүхдийн насны онцлог, хөгжилд тохирсон хэрэгцээт тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хандивлалаа.



Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөр

Уурхайн нөлөөллийн бүсийн малчид, иргэдийн эрхийг хүндэтгэн тэдний өөрсдийн сонгосон жижиг, дунд бизнесийг дэмжиж, хамтран хөгжүүлэх зорилгоор “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр” -ийг 2014 оноос хойш тууштай хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд иргэдэд жижиг, дунд бизнес эрхлэхэд нь 10 хүртэлх сая төгрөгийн зээлийг хүүгүй олгож, санхүүжилт ба эрсдлийг компаниас 100% хариуцан ажилладаг. Тус хөтөлбөрийн зээлийн санд зориулан 2014-2021 онд 250 сая төгрөгийг орон нутгийн Хас банкинд байршуулсан бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 81 иргэнд 609 сая төгрөгийн хүүгүй зээлийг гурав хүртэл жилийн хугацаатай олгожээ.

2022 онд Цогтцэций сумын 23 иргэнд нийт 216 сая төгрөгийн зээл олгож, зээлийн эргэн төлөлт нь хэвийн нөхцөлтэй явагдаж байна. Хөтөлбөрийн үр дүнгээс харахад олон жилийн хугацаанд тогтвортой үргэлжилж буй уг зээлийн хөтөлбөр нь орон нутгийн жижиг бизнесүүдэд бодит дэмжлэг болж, үр дүнтэй хэрэгжиж байна.

Бид орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжих бодлогын хүрээнд 2017 оноос “Зул цэций урлан” орон нутгийн эмэгтэйчүүдийн оёдлын цехтэй худалдан авалтын гэрээ хийж хамтран ажилласаар ирсэн. Мөн эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор оёдлын бизнес эрхлэх хүсэлтэй 10 гаруй эмэгтэйчүүдийг нэгтгэн хөнгөлөлттэй үнэ бүхий 210 кв талбай бүхий түрээсийн ажлын байраар хангаж, нүүрсний машины бүтээлэг, ажлын хувцасны захиалга өгч гэрээлэн ажилласнаар эдгээр эмэгтэйчүүдийг өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлээ. Мөн тоног төхөөрөмжийн сайжруулалт хийснээр бүтээгдэхүүний чанар, гарц нь нэмэгдсэн эерэг үр дүнтэй байна.



ОНЦЛОХ КЭЙС

Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөрийн оролцогч Д.Бадамханд: “Гэр бүлийн хүн маань Энержи Ресурс компанид Тээврийн менежерээр ажилладаг. Бид гэр бүлээрээ Цогтцэцийд шилжин суурьшаад 11 жил болж байна. Анхандаа гэрээрээ хоол, нарийн боов хийдэг байсан. Хиншүү их байна гэж гэрийнхэн дургүйцэхээр нь бизнесээ өргөжүүлж, арай өөрөөр ажиллахаар шийдээд, “Цэций” хороололдоо “My food” нэртэй хоолны газар нээсэн. Ингэхдээ компаниас шилжин суурьшсан ажилласдын ар гэрийг дэмжих, жижиг, дунд бизнесийг дэмждэг хөтөлбөрт хандаад гурван жилийн хугацаатай хүүгүй зээл аваад тоног төхөөрөмжөө авсан. Одоо манай кафе уурхайчдын “Цэций” хорооллынхны байнгын үйлчлүлдэг газруудын нэг болсонд баяртай байдаг”



ОНЦЛОХ КЭЙС

Цогтцэций сумын иргэн С.Түмэнцэцэг: “Энержи Ресурсын “Ойн зурвас”-т хүнсний ногоо тариалаад арав гаруй жил болж байна. Мөн энд ногоо тарьдаг хүмүүстэйгээ нийлээд “Ургац” нэртэй бүлгэм байгуулсан. Бид тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж модны үржүүлэг хийх зорилгоор 50 мянган модны үрсэлгээ тарьсан. Миний хувьд тэтгэвэртээ сууж байна гээд гар хумхилгүйгээр ийм сайхан байгальд мод, ногоогоо тариад цагийг үр дүнтэй өнгөрүүлдэгтээ маш их баяртай байдаг. Энэ олон мод ургамал манай говийн байгаль экологид ээлтэй, энд ногоо тарьж хөдөлмөрлөж байгаа маань бидний эрүүл мэнд, ахуй амьдралд маань ч ач тустай шүү дээ. Ард иргэд, сум оронд маань дандаа тустай зүйл хийж байдаг энэ компанидаа үргэлж талархаж явдаг”



Газар тариалан, хүнсний ногоо тарилтыг дэмжих төсөл

Цөлжилт, хөрсний доройтлын эсрэг Цогтцэций суманд “Ойн зурвас” салхины хаалт байгуулах төсөл 2011 оноос амжилттай хэрэгжиж байна. “Ойн зурвас”-ын найман га талбайг сумын иргэд болон шилжин суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийн газар тариалан эрхлэх идэвхи санаачилгыг дэмжих, туршлага, ур чадварыг нь нэмэгдүүлэх, цаашлаад өрхийн бизнесийг нь чадавхижуулах зорилгоор ашиглуулж байна.

2022 оны хувьд таван га талбайд нийт 57 өрх, нэг аж ахуй нэгж 20 гаруй төрлийн төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тариалж, 95 орчим тонн ургац хураан авсан. Өөрсдийн санаачилгаараа нэгдсэн “Ургац” бүлгийн ногоочид борлуулалт, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээг сайжруулах, зоорьтой болох, мод үржүүлгийн бизнес эрхлэх зэрэг асуудлаа хамтын хүчээр шийдвэрлэх зорилго тавин ажиллаж байна.

Цогтцэций сумын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан “Алтан намар-2022” ургацын баяр, үзэсгэлэн худалдаанд 70 гаруй иргэд, аж ахуй нэгж оролцлоо. Ногооны талбайн усалгаанд нийт 17,000 м3 ус зарцуулсан. Мөн газар тариалангийн талбайн туслах ажилтнаар орон нутгийн иргэнийг ажлын байраар ханган таван сарын хугацаанд цалинжуулан ажиллуулсан байна.

“УХАА ХУДАГ НААДАМ 2022”



Говь нутгийн өв, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, нутгийн зон олонд хүндэтгэл үзүүлэх, орон нутагт шилжин суурьшсан ажиллагсаддаа урам зориг өгөх зорилготой “Ухаа худаг” наадам жил бүр уламжлал болон зохиогдож ирсэн. 2022 оны 8-р сарын 12-13-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд зохион байгуулсан “Ухаа худаг” наадамд нутаг нутгийн хүчит бөхчүүд зодоглож, хурдан хүлгүүд нь шандсаа өргөж, мэргэн харваачид нь цэцээ сорилоо. Тус наадамд улс, аймаг, сумын цолтой

128 хүчит бөх, өсвөрийн 32 бөх, Энержи Ресурс компанийн ажиллагсдын төлөөлөл 48 бөх хүч үзэн барилдаж, хурдан морины уралдаанд 11 аймгийн, нийт 5 насны 140 шандаст хурдан хүлэг уралдсан юм. Сурын харваанд улс, аймгийн цолтой, чансаа өндөр 103 мэргэн харваач, өсвөрийн 34 харваач оролцлоо. Мөн наадмын үеэр циркийн тоглолт, хүүхдийн дууны уралдаан, үдшийн шоу цэнгээн, амьд хөгжлийн тоглолтууд зохиогдож, нийт 100 гаруй уран бүтээлч оролцсон байна.

“САЙН ХӨРШ” ХӨТӨЛБӨР

Бид сум орон нутгийн иргэдэд тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийг хөнгөвчлөх, тусламж үзүүлэх, Цогтцэций сумын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээнд байнгын дэмжлэг үзүүлэх зэрэг үүднээс урт хугацаанд байнга хэрэгжих “Сайн хөрш” хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн билээ. Уг хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн оролцогч талуудтай тогтмол хамтран ажилладаг. Тайлант онд иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй сайн хөршийн харилцааг эрхэмлэж, сумдыг эрчим хүчин нүүрсээр хангах, малчин өрхүүдэд өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг уламжлалын дагуу зохион байгуулж, орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих ажлуудаа тууштай үргэлжлүүлэн ажиллалаа.

Ус түгээлтийн байдал (2022)



2.4 мян.м³
Оторчдын малын усалгаа



Эрчим хүчний нүүрсний хангалт

Өмнөговь аймаг болон ойролцоох сумдын өвөлжилтийн хэрэгцээнд зориулан жил бүр 30,000 орчим тонн эрчим хүчний нүүрсээр ханган ажиллаж байна. Тодруулбал, 2009 оноос хойш Даланзадгадын дулааны цахилгаан станц, Цогтцэций, Баян-Овоо, Булган, Хүрмэн, Мандал-Овоо, Манлай, Номгон, Ханбогд, Цогт-Овоо, Сэврэй, Ханхонгор сумдын эрчим хүч болон албан газруудын хэрэгцээний нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлсээр ирсэн.

2022 онд дээрхи газруудад нийт 913.7 сая төгрөгийн өртөг бүхий 20,768 тонн нүүрсийг тус тус үнэ төлбөргүй нийлүүлж, олон айл өрх, албан байгууллагуудыг дулаан өвөлжихөд нь хувь нэмрээ орууллаа.

Цогтцэций сумын агаарын бохирдол, утааг бууруулах ажлын хүрээнд сумын ЗДТГ-тай гэрээ байгуулж нийт 3,000 тонн эрчим хүчний, угаасан нүүрсийг гурван жилийн турш нийлүүлэхээр боллоо. Сумын эрчим хүч, нэгдсэн халаалтад холбогдоогүй байгууллагууд, зорилтот бүлгийн айл өрхүүдэд тайлант онд 3,271 тонн нүүрс үнэ төлбөргүй олгожээ.

Ус хангамж

Бид ус хангамжийн системийнхээ хүрээнд уурхайн болон үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангахаас гадна Цогтцэций сумыг ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Тодруулбал, говийн хатуулаг ихтэй, шууд унданд хэрэглэхэд тохиромжгүй усыг өөрсдийн зардлаар бүрэн цэвэршүүлж, ундны усны стандартад нийцүүлэн нийлүүлдэг. Дунджаар жилд 120,000 м³ цэвэршүүлсэн усыг сумын иргэдэд улсын суурь үнээр нийлүүлж байна. Түүнчлэн Цогтцэций сумын төв, Ажилчдын хотхон, “Цэций” хорооллыг ариутгах татуургын нэгдсэн системд холбосон бөгөөд сумын төвд орчин үеийн, европ стандартын, хоногт 1,200 тонн бохир ус хүлээж авч цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ажиллаж байна.


2022 онд Цогтцэций сумын иргэдийн унд ахуйн хэрэгцээнд 132.7 мянган м³ цэвэршүүлсэн ундны усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөөврөөр, иргэд оторчдын малын усалгаанд 2,379 м³, сумын иргэдийн хүнсний ногооны талбайн усалгаанд 17.4 мянган м³ усыг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүйгээр, аж ахуйн нэгж, байгууллагуудад 71.6 мянган м³ усыг тус тус түгээсэн байна. Мөн онд сумын цэвэрлэх байгууламж нь 134 мянган м³ ахуйн бохир усыг төвлөрсөн шугам сүлжээ болон зөөврөөр хүлээн авч цэвэрлэжээ.

Бэлчээрийн усан хангамж

Орон нутгийн малчдын хэрэгцээнд үндэслэн бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оноос хойш жил бүр зун, намрын улиралд ус хангамжийн системийн гол шугамаас мал усалгааны зориулалтаар усны гаргалгаа цорго нээж өгсөөр ирсэн. Тайлант онд Цагаан-Овоо багийн малчид болон отрын малчдын хүсэлтээр Ус хангамжийн гүний 6, 10-р худгуудын дэргэд мал усалгааны зориулалттай худгийн хоёр гаргалгааг малчдад нээж өглөө. Ингэснээр нийт арав орчим өрхийн 6,000 гаруй малын усалгааны хэрэгцээ хангагдаж, отор нүүдэл хийж яваа малчдын хөдөлмөрийг хялбарчилж байна. Мал услах ажлыг нь хөнгөвчилж жил бүр гурав хүртэлх гаргалгаа гаргаж өгдөг уламжлалыг орон нутгийн малчид талархан хүлээж авдаг.

Хүнсний тусламж

Сүүлийн жилүүдэд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт зэрэг нь орон нутгийн эмзэг ба зорилтот бүлгийн айл өрхүүдийн амьжиргаанд нөлөөлж амьжиргааны түвшинг доройтуулсаар байна. Бид “Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд 2022 онд Цогтцэций сумын зорилтот бүлгийн 200 өрхөд хүнсний багц хүргэж хүмүүнлэгийн үйл ажиллагаа зохион байгууллаа. Хүнсний тусламжийн хүрээнд зорилтот өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, цаашид тогтвортой амьжиргааг нь дэмжих чиглэлд олон төрөлт ажлууд хийхээр төлөвлөж байна.



Өвс, тэжээлийн дэмжлэг

Сүүлийн арав гаруй жилийн турш малчдад өвөл, хаврын хүнд хахир үеийг хохирол багатай даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор өвс, тэжээлийн тусламж үзүүлсээр ирсэн. Жилд дунджаар 9-10 мянган боодол өвс, 50 орчим тонн тэжээл татан авч бэлддэг. 2022 онд 8,000 боодол өвс, 45 тонн тэжээл татан авч нөлөөллийн бүсийн 455 малчин өрхөд дэмжлэг үзүүлэв. Мөн Баян-Овоо, Цогт-Овоо, Номгон, Ханхонгор, Манлай сумын фондоод тус бүр нь 500 боодол өвс, Ханхонгор сумын Хондот багийн 30 гаруй өрхүүдэд өвс тэжээл, долооц тараав. Мөн говийн зэрлэг амьтдад зориулж, байгаль орчны дүйцүүлэн хамгаалах ажилд 230 боодол өвс хандивлажээ.

Ахмадуудын хүндэтгэл

Сар шинийг тохиолдуулан жил бүр Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын 70-аас дээш насны ахмад буурлуудад хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. 2022 онд Цогтцэций, Ханхонгор сумдын 70-аас дээш насны нийт 250 ахмадад хүндэтгэл үзүүлж, хүнсний багц гардууллаа. Мөн Ахмадын баярыг угтан Цогтцэций сумын 186 ахмадыг хүлээн авч, урлагийн тоглоолтоор бэлэг бариллаа.

ОРОН НУТГИЙН ХАНДИВ, ТУСЛАМЖ



Орон нутаг, оролцогч талуудын сайн хөршийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор зайлшгүй шаардлагатай үед мөнгөн болон эд материалын хандив, тусламжийг компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд үзүүлсээр ирсэн. Тайлант онд орон нутгийн хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлагын хүрээнд сум, орон нутгийн төрийн байгууллагуудад холбогдох хандив тусламжийг үзүүллээ. Тухайлбал, Цогтцэций суманд хэрэгжиж байгаа “Модтой хашаа” төслийг дэмжиж 60 өрхөд таван төрлийн 2,100 гаруй суулгац, Цогтцэций суманд 1,000 суулгац, Цогт-Овоо суманд 500 суулгац тус тус хандивласан бол орон нутгийн ТББ-уудын хүчин чадавхийг дэмжих, үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр уурхайчин залууст зориулсан эрүүл мэнд, спортын арга хэмжээг ивээн тэтгэж ажиллалаа. Тайлант онд аймаг, сумдын тэмдэглэлт ой тохиосонтой холбогдуулан Өмнөговь аймгийн 100 жилийн ойд 500 сая төгрөг, Ханхонгор сумын Хондот, Жаргалант багийн баяр наадамд 15 сая төгрөг, Цогтцэций сумын 1-р сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж, 7-р цэцэрлэгт хүүхдийн тоглоом зэрэг нийт **1.7 ТЭРБУМ** төгрөгний хандив, тусламж үзүүлж хамтран ажиллалаа.

VI. АЖИЛЛАГСАД

 **1,979**
(2021: 1,880)

Нийт үндсэн ажиллагсдын тоо

 **31%**
(2021: 33%)

Удирдлагын түвшинд эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь

 **96** тэрбум
(2021: 68 тэрбум)

Цалин, урамшууллын зардал

 **4%**
(2021: 4%)

Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдын эзлэх хувь хэмжээ

Энержи Ресурс компани нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 60 гаруй хууль журмыг мөрдөн ажиллахаас гадна Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг чанд дагаж биелүүлдэг.

Эдгээр хууль тогтоомж, дүрэм журмын дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны аливаа дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрддөг.

Компанийн зүгээс ажлын байрыг нээлттэй, ил тод, шударгаар зарлаж

хөдөлмөрийн зах зээл дээрээс хүний нөөцийн бүрдүүлэлт үүсгэн ажилладаг. 2022 оны 12-р сарын эцсийн байдлаар тус компани нийт 1,979 үндсэн ажиллагсадтай ба түүний 39%-ийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Баян-Овоо, Ханхонгор сумын иргэд зонхилон бүрдүүлж байна. Түүнчлэн Ухаа худаг цогцолборын хүрээнд шууд ба шууд бусаар нийт 5,000 орчим хүнийг ажлын байраар хангаж байна.

2022 онд 761 ажлын байр шинээр бий болгож, зайнаас ажиллах уян хатан бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Тухайлбал, 6-аас доош насны хүүхэдтэй эмэгтэй ажиллагсдыг долоон хоногийн ажлын дөрвөн өдөр оффисоос, нэг өдөр гэрээс ажиллуулах, оффисын нийт ажиллагсдын ажлын цагийг өглөө 08-10, орой 17-19 буюу уян хатан ирүүлэх гэх мэт зохицуулалтуудаа хэвээр хадгалж байна.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЗАРЧИМ, ТЭГШ БОЛОМЖ

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдынхаа эрхийг нэн тэргүүнд дээдэлж, бүх ажиллагсдыг ижил тэгш боломжоор хангахыг зорьдог.

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харьяалал зэргээс үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин,


туршлага болон дэв зэргээс хамаардаг. 2022 онд нийт ажиллагсдын ойролцоогоор 15%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд удирдах түвшний ажилтнуудын 31% нь эмэгтэйчүүд байгаа нь дотоодын төдийгүй олон улс дахь уул уурхайн салбарын дунджаас дээгүүр үзүүлэлт юм. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. Орон нутагт ээлжээр ажилладаг эмэгтэй ажиллагсдын байр, орон сууцны нөхцлийг сайжруулах ажлууд байнга хийгдэж ирсэн. Ажиллагсдыг насны ангиллаар нь авч үзвэл нийт ажиллагсдын дийлэнхи буюу 62%-ийг 30-50 хүртэлх насныхан, 31%-ийг 30 хүртэлх насныхан бүрдүүлж байна.

2022 онд нийт 74 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж тогтмол орлоготой байхад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Ингэснээр Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нийт ажиллагсдын дөрөв ба түүнээс дээш хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохицуулалтыг бүрэн ханган ажиллаж байна.

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн хангамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Ажилтнуудаа орон сууц, даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, бизнес эрхлэх, тав тухтай шилжин суурьшиж, “хөлөө олох”-од нь туслах, ажиллагсдын хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр нийгмийн асуудалд нь нэн тэргүүнд анхаарал хандуулсаар ирсэн.

2022 онд нийт ажиллагсдын нийгмийн даатгал, цалин урамшуулалд 96 тэрбум төгрөг олгосон байна.

ҮНДСЭН АЖИЛЛАГСАД



ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2020	2021	2022
I.	30 хүртэлх насны ажиллагсад	30%	26%	31%
II.	30-50 хүртэлх насны ажиллагсад	64%	68%	62%
III.	50-с дээш насны ажиллагсад	6%	6%	7%
IV.	Эмэгтэй ажиллагсад	13%	14%	15%
V.	Удирдах түвшний эмэгтэй ажиллагсад	32%	33%	31%
VI.	Удирдах зөвлөл дэх эмэгтэйчүүд	12%	12%	12%
VII.	Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсад	4%	4%	4%

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн орон нутгийн, мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн.

Ур чадварын үнэлгээнээс ажиллагсдын ерөнхий болон мэргэжлийн ур чадварын сургалтуудын төрлийг тодорхойлдог. 2022 онд давхардсан тоогоор нийт 15,102 ажиллагсдыг 82 төрлийн сургалтад хамруулсан бөгөөд үүнээс 12,939 хүнийг ерөнхий ур чадварын, 2,163 хүнийг нарийн мэргэжлийн сургалтанд тус тус хамруулжээ. Тодруулбал 80,673 хүн/цаг сургалт явагдсан бөгөөд нэг ажилтанд дунджаар 5.34 цагийн сургалт ногдож байна.

Мөн тайлант хугацаанд үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэлтэй буюу тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллах иргэн, ажилтнуудад сургалт зохион байгуулах эрхийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвөөс авч 746 хүнд сургалт зохион байгуулсан. Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нарийн мэргэжлийн 44 сургагчтай бөгөөд сургагч нарыг

тасралтгүй хөгжүүлэх зарчмыг баримтлан ажлын байранд сурч хөгжих бололцоог бүрдүүлэхээс гадна мэргэжил ур чадварыг дээшлүүлэхээр сургалтын байгууллагуудаас 12 төрлийн сургалт авч давхардсан тоогоор 104 сургагчийг мэргэшүүлсэн байна.

Хэдийгээр уул уурхай нь эрчүүд давамгайлсан салбар гэгддэг ч компанийн зүгээс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байрны тэгш боломжоор хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. 2022 онд 18 эмэгтэйг хүнд машин механизмын оператор мэргэжил олгох сургалтанд хамруулан, ажлын байраар хангажээ.



Сургалтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн үзүүлэлт (2022)

Операторын давтан сургалт

174

Нийт операторын давтан сургалтын 13%

Операторын мэргэжил олгох сургалт

18

Нийт операторын мэргэжил олгох сургалтын 23%

Тайлант хугацаанд орон сууцны “Цэций” хороололд 37 ажилтныг, “Уурхайчин” хороололд 37 ажилтныг гэр бүлийн хамт тус тус суурьшуулсан. Тогтвортой ажиллах гэрээний үүргээ биелүүлсэн нийт 74 ажилтанд орон сууц болон хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн байна. 2022 онд “Уурхайчин” хороололд 163 айлын хашааг шинээр нэмж бариулсан. Компанийн нийт ажилтнуудын 48% нь тогтвор суурьшилтайгаар дөрөв болон түүнээс дээш жил ажиллаж байгаа нь компанийн зүгээс ажилтнуудаа ижил, тэгж боломжоор хангаж ирсний үр дүн юм.

Мөн онд бид шинээр 761 хүнийг шинээр ажлын байраар хангасан байна. Хэдийгээр хөдөө орон нутагт чадварлаг, мэргэжлийн боловсон хүчний нөөц туйлын дутмаг байдаг ч ажиллагсдын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байдаг нь компанийн зүгээс ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр хадгалан, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм.

“Байгууллагын соёлын судалгаа”-наас харвал, ажиллагсдын 90 орчим нь эрхэлж буй ажилдаа болон компанидаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн бөгөөд нийт ажилтнуудын 40% нь тогтвор суурьшилтайгаар 5 болон түүнээс дээш жил ажиллаж байна.

2022 онд компанийн ажилтнуудаас санаачилсан орон нутгийн иргэдийн хашаандаа мод тарих хүсэлтийг дэмжиж, идэвхижүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “Модтой хашаа” төсөл болон Үндэсний мод тарих өдрөөр Цогтцэций суманд мод тарих зэрэг сайн дурын ажлуудад нийт 150 орчим ажиллагсад хамрагдан 300 цагийг зарцуулжээ.



ОНЦЛОХ КЭЙС

Ухаа худаг уурхайн сургалтын ажилтан Б.Батсайхан: “Анх 2010 онд уулын туслах ажилчнаас ажлын гараагаа эхэлж байлаа. Удалгүй компаниас зохион байгуулсан сургалтанд хамрагдаж Хүнд машин механизмын операторын мэргэжил эзэмшсэн. Оператороор ажиллаж байх хугацаандаа өөрийн ур чадвараа дайчлан хамт олонтойгоо Liebherr 996 экскаватороор дэлхийн рекордыг дөрвөн удаа шинэчлэн тогтоосон амжилт минь энэ мэргэжлээрээ бахархах гол шалтгаан болдог. 2018 оноос эхлэн компанийнхаа сургалтын ажилтан болсноор 300 гаруй залууст энэ сайхан ажил мэргэжлийг эзэмшүүлэх үйлсэд өөрийн туршлага, ур чадвараа зориулсан байна”

VII. БАЙГАЛЬ ОРЧИН

631,679

(2021: 179,496)

**Хүлэмжийн хийн
ялгарал ТҮВШИН 1**

Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн бүхий л үе шатанд байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, олон улсын стандартуудыг даган мөрдөж, үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг.

Бид үйл ажиллагаагаа Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай, Эрүүл ахуйн тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай зэрэг Монгол Улсын 30 орчим хуулиуд болон бусад холбогдох 200 гаруй хууль тогтоомж, журам заавар, стандартын дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

Түүнчлэн Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (БОХАБЭА)-н бодлогын хүрээнд олон улсын ISO 14001:2015 "Байгаль орчны менежментийн тогтолцоо", ISO 45001:2018 "Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо" болон ISO 9001:2015 "Чанарын менежментийн тогтолцоо" стандартын шаардлагатай нийцүүлсэн, Нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү Нэгдсэн менежментийн тогтолцоо нь БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг. Бид нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц зэрэг гол бүтээн байгуулалтууддаа говийн нөхцөлд

2,753

(2021: 80,613)

**Хүлэмжийн хийн
ялгарал ТҮВШИН 2**

тохирсон байгаль орчинд ээлтэй, ус хамгийн бага ашиглах технологийг ашигладаг.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөг жил бүр боловсруулан, төрийн захиргааны байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэн ажилладаг. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасны төлөвлөгөөний биелэлт нь 90%-иас дээш байх шаардлагатай байдаг.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн ЗДТГ, газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Цогтцэций сумын Уул уурхай, ус хариуцсан байгаль хамгаалагч, Орон нутаг хариуцсан байгаль хамгаалагч, сумын багийн дарга нар болон сумын иргэний төлөөллийн бүрэлдэхүүнтэй комисс компанийн 2022 оны төлөвлөгөөний биелэлтийг 96.5%-тай гэж дүгнэсэн.

Компани говь нутагт ногоон байгууламж, таримал ойн санг нэмэгдүүлэх зорилгоор нөхөн сэргээлтийг анхнаас нь үе шаттай төлөвлөх, түүнд шаардлагатай туршилтын талбайг бий болгох, суулгацуулыг өөрсдөө жил тутам бэлтгэж, арчлан ургуулах зарчмаар ажиллаж ирлээ. 2009 оноос хойш нийт 220,000 гаруй мод тарьж ургуулснаас, 2022 онд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 11,100 орчим тарьцыг үржүүлэн бойжуулж, 93,000 гаруй мод сөөгний суулгац тарьсан бөгөөд нийт модны амьдралтын хувь 85%-иас дээш байна.

НӨХӨН СЭРГЭЭЛТ

Газрыг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээж улмаар ирээдүйд бэлчээр болон бусад байдлаар ашиглах боломжтой болгож үлдээх нь хариуцлагатай уул уурхайн нэн чухал хэсэг юм.

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд барих зорилго тавин ажилладаг



Хаягдлын овоолгын нөхөн сэргээлт

Ухаа худаг уурхайн Техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан гадаад овоолгын техникийн ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, зохих аргачлалын дагуу хийх ажлыг 2011 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тайлант онд уурхайн хаягдлын овоолгын налуулж, хэлбэршүүлсэн талбайг шимт хөрсөөр хучиж, биологийн нөхөн сэргээлт хийх эхний үе шатны ажлыг 10 га талбайд, шимт хөрсөөр хучсан хэсэгт ургамалжуулалт хийж, биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэх ажлыг 2022 онд нэг га талбайд мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн ба биологийн нөхөн сэргээлт хийсэн нийт талбайг Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдэд танилцуулсан.

бөгөөд жил бүр нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. 2020-2022 онд нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд уурхайн хаягдлын овоолгын 42 га талбайг налуулж, хэлбэршүүлэн үндэсний стандартад нийцүүлэн техникийн нөхөн сэргээлт хийсэн ба 20 га талбайг шимт хөрсөөр хучих, 3 га талбайг ургамалжуулах ажлыг гүйцэтгэн, биологийн нөхөн сэргээлт хийсэн.



Байгаль орчны дүйцүүлэн хамгаалал

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон нийт 8,000 га талбайг нөхөн сэргээх "Нөхөн сэргээлт 2024" нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тусгагдсан. Энэхүү зорилгод манай компани нэгдэж, 2022 онд гар аргаар алт олборлолтын улмаас эвдрэлтэнд орсон, Өмнөговь аймгийн Баяндалай сумын Баян цагааны нуруунд долоон га талбайд техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу амжилттай хийж гүйцэтгэсэн. Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийснээр зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулж хүн, мал амьтан унаж бэртэх, осол эрсдлийг бууруулж байна.

220 мянга

**Нийт ургуулсан мод,
сөөг**

12.9%

(2021: 26.5%)

**Хог хаягдлын дахин
боловсруулалт**

96.5%

(2021: 92.2%)

**Хяналт
шалгалтын дүн**

УС ХАНГАМЖИЙН ЦОГЦ МЕНЕЖМЕНТ

Ухаа худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангадаг.

Монгол Улсын Усны тухай хууль, MNS 4943:2015 үндэсний стандартыг мөрдөхөөс гадна Олон Улсын Санхүүгийн Корпорацийн санаачилга “Өмнийн говийн усны менежементийн Сайн дурын кодекс”-ын гишүүнээр элсэж, гарын үсэг зуран нэгдсэн бөгөөд усны хэмнэлт, дахин ашиглалтын мэдээллээ сайн дураар тайлагнадаг.

Говь нутгийн ус нь эрдэсжилт, хатуулаг ихтэй учраас ундны усанд тогтмол хэрэглэх нь тохиромжгүй байдаг. Иймд Энержи Ресурс компани ундны усыг цэнгэгжүүлж, Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажиллагсдын хотхоныг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангасаар ирсэн. Усны хэрэглээ, олборлосон ус, хэрэглэсэн ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээг хянахын тулд бид бодит цагийн мэдээлэл цуглуулах нэгдсэн телеметрийн хяналтын системийг ашигладаг.

Ухаа худагийн цахилгаан станц л гэхэд усаар хөргөх бус хуурай хөргөлтийн системтэй тул ердийн цахилгаан

станцуудаас 4-5 дахин бага ус ашиглах технологитой. Түүнчлэн нүүрс баяжуулах үйлдвэрийнхээ дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг ажиллуулж, хаягдал лагаас усыг шавхаж авах замаар усны дахин ашиглалтыг 95%-д хүргээд байгаа билээ. Мөн ус уурших, шүүрэхээс бүрэн хамгаалагдсан, 56,000 м3 ус агуулах хоёр ширхэг усан сан нь усны ууршилт, нэвчилтийг бүрэн хязгаарласан дэвшилтэт технологийн шийдэлтэй.

Бид уурхайн талбайд гүний болон дахин боловсруулсан усыг хослуулан ашигладаг.

- Тайлант онд нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр ажилласнаар 663,236 м3, цахилгаан станцын концентрацитай усыг гадаргын ус цуглуулах цөөрөмд цуглуулан 33,183 м3 усыг дахин ашигласан байна.
- 134,000 м3 ахуйн бохир усыг цэвэршүүлж, мод услах, уурхайн тоос дарах зэрэгт ашигласан.
- Малчдын худгийн усны түвшин, уурхайн орчмын цооног болон ус олборлох талбайн усны түвшний хэмжээг сар бүр хянаж, хэмжилт хийсэн.

Мөн ахуйн зориулалтын усны хэрэглээг бууруулах ажлын хүрээнд Дэлхийн усны өдрийг тохиолдуулан ерөнхий боловсролын сургуулийн 130 сурагчад “Усны хэрэглээ” сэдвээр сургалт зохион байгууллаа.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Ухаа худаг төслийн үйл ажиллагааны явцад үүсэх үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг тодорхойлох, хаягдлыг ангилах, дахин ангилах, хог үүсэлтийн хэмжээг бууруулах, дахин боловсруулах, хэрэглээнд нийлүүлэх зорилгоор хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг үүсгэж, хяналт шинжилгээ тогтмол хийдэг.

Мөн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ “3R+R” системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

2022 онд уурхайн талбайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хатуу хог хаягдлын нийт хэмжээ 9,235 м3 байсан бөгөөд хог хаягдлын 12.9%-г дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн байна. Төслийн үйл ажиллагааны явцад бий болсон хог хаягдлыг хог хаягдлын цуглуулалт, тээвэр устгалын эрх бүхий “Паблик сервис” ХХК-тай гэрээ байгуулан, тээвэрлүүлж, устгуулдаг.

Мөн төслийн нийт талбайн хэмжээнд их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг нийт 19 удаа зохион байгуулж, нийт 8.15 м3 хог хаягдлыг цуглуулж төвлөрсөн цэгт хүргүүлсэн бол сум орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд үндсэн болон гэрээт компанийн 64 хүн оролцож нийт 8 м3 хог хаягдлыг түүж цуглуулан цэвэрлэсэн.

Хог хаягдлын нэр төрлүүдийг тогтоон, ангилан ялгалт хийж, дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх, нийлүүлэгч байгууллагад буцаах байдлаар ажиллаж байна. Ажлын бүх байранд хог хаягдал ангилан ялгаж зориулалтын савыг байрлуулсан ба ажилчдад хог хаягдлын менежментийн зохистой дадал хэвшлийн талаарх сургалт мэдээллийг тогтмол олгодог. Үр дүнд нь, ажиллагсдын хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж хаях дадал жилээс жилд сайжирч байна.

Тайлант жилд 1,150 ширхэг хүнд даацын автомашины хаягдал дугуйг таван малчин өрхөд малын хашаа хороо барих зориулалтаар, орон нутгийн иргэнд 13.2 м3 хаягдал модыг, 65.4 тонн хаягдал төмрийг орон нутгийн хаягдал төмөр хүлээн авдаг “Ганцэций” ХХК-д, мөн 6.05 тонн хуванцар сав, 142 кг пакетны зөөлөн гялгар уут, 700 кг цаасан бүтээгдэхүүний хаягдлыг орон нутгийн хаягдал хүлээн авдаг “Дүүрэн цэций” ХХК-д тус тус хүлээлгэн өгсөн байна.

Аюултай хог хаягдал

Бид аюултай хог хаягдлын менежментийн бодлогынхоо дагуу бүх төрлийн аюултай хог хаягдлын шинж чанар, эрсдлийг тодорхойлж, үнэлэхийг шаарддаг. Энэ дагуу аюултай материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглах, шилжүүлэх, устгахтай холбоотой урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тайлант хугацаанд дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн аюултай хог хаягдлын эзлэх хувь 16 орчим байсан нь өмнөх оны үзүүлэлттэй ижил түвшинд байна.

Аюултай хог хаягдлыг төрлөөс нь хамааруулан дахин боловсруулах эсвэл зохих ёсоор устгах зорилгоор эрх бүхий байгууллагад өгөх болон нийлүүлэгчид буцааж хүргэдэг. Тухайлбал, тайлант онд нийт 364 хүнд машин механизмын ашигласан аккумуляторыг хог боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгжид, 170 аккумуляторыг нийлүүлэгчид хүргүүлжээ. Ашигласан тосыг цуглуулж, дахин боловсруулах нь газрын гадарга, хөрс, гүний усыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. 2022 онд 313 тонн ашигласан тосыг зориулалтын саванд цуглуулан түлш болон бусад төрлийн түүхий эд үйлдвэрлэдэг дахин боловсруулах үйлдвэрт илгээсэн байна. Мөн бид Ухаа худаг уурхайн цогцолбортоо химийн бодис хадгалах зориулалтын агуулахтай болсноор химийн бодисны ашиглалт, зөөвөрлөлттэй холбоотой хүрээлэн буй орчинд учирч болох эрсдлийг үлэмж хэмжээгээр бууруулаад байна.

 **106 литр/ром.тонн**
(2021: 111 литр/ром.тонн)

Үйлдвэрлэлд усны дахин ашиглалт

АГААРЫН ЧАНАР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт болон агаар бохирдуулагч хийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой ажлууд хийж хэрэгжүүлдэг. Ухаа худаг уурхайн хүрээнд дуу, шуугианы эх үүсвэр, түвшнийг тогтмол үнэлж хянадаг. Мөн тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор тоосны хэмжилтийг Ухаа худаг уурхай, Цогтцэций сум, Цагаан хадан дахь тодорхой цэгүүдэд тогтмол хийсээр ирсэн. Тайлант хугацаанд дээрх цэгүүдэд MNS 4585:2016 стандартын дагуу PM2.5-ын түвшний хэмжилтийг 100 гаруй удаа хийжээ. Хилийн туршид PM2.5-ын дундаж түвшин ихэнх хэмжилтийн цэгүүдэд агаарын чанарын улсын стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс (0.05 мг/м3)

АГААР БОХИРДУУЛАГЧ ХИЙН ХЭМЖЭЭ (ТОНН)			
ХИЙ		2021	2022
I.	NOx	50.1	85.6
II.	SOx	0.7	1.2
III.	PM	4.6	6.2

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Уур амьсгалын өөрчлөлт, нүүрсхүчлийн хийн ялгарлын эсрэг дэлхий нийтийн хүчин чармайлт эрчимжиж байгаа энэ үед уул уурхайн компаниуд эдгээр ялгаруулалтыг бууруулах, эрсдлийг тооцоолох, урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга, технологи дээр илүү шаргуу ажиллаж байна.

Бид 2017 оноос эхлэн компанийн үйл ажиллагааны явцад үүсч байгаа хүлэмжийн хийн ялгарлыг хянах зорилгоор ялгарч буй хүлэмжийн хийн тооцооллыг гарган, тайлагнаж эхэлсэн. Уг ажлын хүрээнд

доогуур байна.

2022 онд компанийн зүгээс нүүрс олборлох явцын тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн технологийн замын материалыг тусгай зориулалтын улаан шавран материалаар засах, технологийн замыг тогтмол услах, тээвэрлэлтийн хурдыг багасгах, цахилгаан станцын нарийн үнс баригч филтерийг горимын дагуу ажиллуулах, нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээлийн туузан дамжуурга дээр суурилуулсан өндөр технологийн тоос цуглуулагч филтерийн засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийж тогтмол ажиллагааг хангах зэрэг ажлыг гүйцэтгэн ажиллалаа.

Орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэргийн агаарт агуулагдах хэмжээг бид агаарын чанарын үндэсний стандарт MNS 4585:2016 стандартын дагуу Ухаа худаг дахь мониторингийн цэгүүд дээрээс сорьц авахуулж, итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлдэг. Тайлант оны хувьд агаар бохирдуулагч хийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс доогуур байна.

хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон цахилгаан станцаас ялгарч буй хүлэмжийн хийн эх үүсвэрээр нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалаар тооцоолж байна. Мөн үлэмжийн хийн ялгарлыг үе шаттайгаар бууруулахаар төлөвлөж, цахилгаан станцаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах үүднээс эх үүсвэрээс нь бууруулах, оффсет буюу жил бүр ногоон байгууламжаа өргөтгөн ойжуулах гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2022 оны хувьд бид хүлэмжийн хийн ялгарлын

тооцооллыг илүү нарийвчилж, 2-р түвшинд нэмэлт тохиргоонуудыг хийснээс гадна 3-р түвшинд шинээр 9 үзүүлэлтийг нэмж, тооцооллын нийт үзүүлэлтүүдийн тоог 15 болголоо. Мөн хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлого арга зүй, шинээр

хийгдэж буй алхмуудын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх үүднээс компанийн ТУЗ-ийн ба гүйцэтгэх удирдлага, дунд шатны холбогдох менежерүүдийг олон улсын үнэлгээний байгууллагын цуврал сургалтанд хамрууллаа.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ		2020	2021	2022
I.	Түвшин 1	257,751	179,496	631,679
II.	Түвшин 2	91,758	80,613	2,753
III.	Түвшин 3	40,653	-6,538	12,590,527
IV.	Үйлдвэрлэл (тонн)	4,719,662	2,449,000	4,264,481
V.	Эрчим	0.083	0.108	3.10

ЭРЧИМ ХҮЧ, УСНЫ ХЭМНЭЛТ

Байгалийн нөөцийг үр ашигтай, хариуцлагатай ашиглах нь байгаль орчны тогтвортой байдалд чухал ач холбогдолтой гэдгийг бид хүлээн зөвшөөрч эрчим хүч, усны хэрэглээгээ тогтмол хянах, тооцоолол хийх, хэмнэлт гаргах чиглэлд анхаарч ажилладаг. Ус, эрчим хүч, түүхий эд зэрэг нөөцийг үр ашигтай, хариуцлагатай ашиглахдаа Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Усны тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиудыг удирдлага болгон ажиллаж байна. Үүний дагуу компани нь эрчим хүч, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглахад чиглэсэн нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогыг баталсан.

Бид үйл ажиллагаандаа гүний болон дахин боловсруулсан усыг хослуулан ашигладаг бөгөөд ус хэмнэх технологиор дамжуулан усны оновчтой үр ашгийг хангахыг зорьдог. Усны хэрэглээ, олборлосон ус, хэрэглэсэн ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээг тогтмол хянахын тулд бид бодит цагийн мэдээлэл цуглуулах нэгдсэн телеметрийн хяналтын системийг ашигладаг.

Ухаа худагийн цахилгаан станц нь эрчим хүчний хэмнэлтийг үе шаттайгаар сайжруулахад чиглэсэн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байдаг. Мөн бид талбайнхаа үйл ажиллагааны бүх түвшинд эрчим хүчний хэмнэлттэй холбоотой практик арга хэмжээ, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, хөргөх цамхагийн хөргөлтийн хөдөлгүүрт давтамж хувиргуур суурилуулах, цахилгаан станцын гэрэлтүүлэгт эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлснээр 2022 онд 610,600 кВт эрчим хүч хэмнэж, нүүрсхүчлийн хийг 952 орчим тонноор бууруулсан байна.

Мөн нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр ажилласнаар 663,236 м3, цахилгаан станцын концентрацитай ус 33,183 м3 усыг тус тус дахин ашигласан байна.

Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд үүрэг хүлээсэн хэрэглэгч, эрчим хүчний аудитыг хийлгэж, жил бүр хэмнэлтийн тайлан гарган ажилладаг.



МОД ҮРЖҮҮЛЭГ

Байгаль орчны нөхөн сэргээлт, орчны тохижилтод зориулж 2009 оноос эхлэн бид Мод үржүүлэг, нөхөн сэргээлтийн тусгай талбай байгуулсан. Уг талбайд мод, сөөг үржүүлж бойжуулах, улмаар тэдгээрийг уурхай, сумын төв, кэмп, орон сууцны хороолол болон зам дагуу шилжүүлэн суулгах ажлууд хийгдэж ирлээ.

2022 оны хавар талбайн хөрс боловсруулалтын ажлыг эхэлж зургаан төрөл зүйлийн 11,100 тарьц үр болон мөчрөөр тарьж ургуулсан байна. Үүнд: Тоорой 1,800, Жигд 2,500, Сухай 3,500, Заг 500, Улиас 800, Хайлаас 2,000 ширхэгийг тус тус үржүүлэн арчилгаа хамгаалалтыг хийсэн. Тоорой модыг үрээр тарималжуулах, ургуулах туршилт судалгааны ажлыг үргэлжлүүлж, Баянхонгор аймаг Эхийн голоос тоорой модны үр түүж мод үржүүлэг туршилтын талбайд шинээр тарилаа.

Тайлант онд 1,800 ширхэг тоорой мод нэмж үрээр тарьсан бөгөөд намрын тооллогоор 87%-тай ургаж байна.



ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Энержи Ресурс компани нь нийт 40 сая модыг үе шаттайгаар тарьж ургуулах амлалт аван ажиллаж байгаа билээ. Ингэхдээ мод тарьж ургуулах урт хугацааны төлөвлөлтийн дагуу говь цөлийн бүсэд хамгаалалтын Ойн зурвас байгуулах замаар газар нутгийг хөрсний доройтол, цөлжилтөөс хамгаалах, ойжуулалтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, тус ажлыг шинжлэх ухааны зохих аргачлалд тулгуурлан ойн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Ойн зурвас маань жил ирэх тусам өргөжин тэлж, өнөөдөр 100 мянга гаруй мод, сөөгтэй, 63 га талбай бүхий томоохон төгөл болжээ.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд тайлант онд нийт 42 га талбайд 93,000 мод тарих ажлыг зохион байгуулав.



БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ХАМГААЛАЛ

Бид 2009 оноос хойш Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг төдөвлөгөөний дагуу хийж ирсэн бөгөөд 2022 оны 2, 4-р саруудад Цогтцэций сумын баруун талд байрлах Хангинах, Номт, Майхан уул зэрэг таван байршилд нийт 80 боодол өвс байршууллаа.

Ийнхүү зэрлэг амьтдад зориудаар ус, өвс тэжээл тавьж байгаа нь хавар, өвлийн хахир цагт тэдгээр амьтдыг идэш тэжээлийн хомсдолд орох, харангадаж эрсдэхээс урьдчилан сэргийлэх уриалготой. Мөн зэрлэг амьтдын ажиглалт хийх зорилгоор Хангинах ууланд автомат камер байрлуулсан. Тайлант онд уулын туруутан амьтдын хамгаалалд зориулж “Говь гурван сайханы байгалийн цогцолбор” газрын хамгаалалтын захиргаанд 200 боодол өвс, Ханбогд сумын ЗДТГ-т 50 боодол өвсийг тус тус хүлээлгэн өгсөн. Цагаан хадны Нүүрс ачиж буулгах талбайн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хүрээнд 2019 онд байгуулсан уст цэгийг тогтмол усаар хангаж, уст цэгийн ойролцоо 20 боодол өвс тавьж, автомат камер байрлуулж биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн.

ШУВУУДЫН АЖИГЛАЛТ, СУДАЛГАА

Шувуудын судалгааг Цогтцэций суманд өөрсдийн байгуулсан Ойн зурвас дээр болон Таван толгой нисэх буудлын орчимд Байгаль орчны мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Шувуудын судалгаанд арга зүйн дагуу гурван харууц цэгийг сонгосноос гадна шугаман замналын дагуу явж бүртгэл хөтөлсөн. Ингэхэд нийт 44 байршлаас 18 зүйлийн 853 бодгалийг бүртгэжээ. Судалгааны үр дүнгээр Ойн зурвасын талбай орчимд гурван багийн 22 зүйлийн 267 амьтныг бүртгэсэн нь өмнөх оны судалгаанаас даруй 7 зүйл, 138 амьтнаар илүү бүртгэгдсэн байна.

ИРГЭДИЙН ОРОЛЦООТ ХЯНАЛТ МОНИТОРИНГ

Ухаа худаг уурхайн Байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгжүүд хамтран байгаль орчны хээрийн хэмжилтийн ажилд иргэдийг сайн дураар оролцуулж, хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд танилцуулах зорилготой ажлыг жил бүр зохион байгуулдаг. Энэ жилийн хамтын оролцоот мониторинг-д иргэдийг оролцуулах ажлыг 6-р сард зохион байгуулж, 10 гаруй иргэнийг хамрууллаа. Усны мониторингийн хэмжилтийг “Адгийн ус” малчдын гар худаг дээр хийж, усны түвшин болон бусад физик- химийн үзүүлэлтүүдийг бодитоор үзүүлж, хэмжилтийг хамтран хийж үр дүнг танилцуулсан. Уг арга хэмжээнд хамрагдсан иргэдийн хүсэлтийн дагуу компанийн мод үржүүлгийн талбай, ногоон байгууламжийг мөн танилцуулж, мод үржүүлэг, арчлалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.



ОНЦЛОХ КЭЙС

Энержи Ресурс компаниас дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ханхонгор суманд зэрлэг амьтдад зориулсан уст цэгийг 2020 онд байгуулж одоог болтол хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Энэхүү худаг нь нарны үүсгүүрээр ажилладаг бөгөөд автомат мэдрэгч төхөөрөмж, ажиглалтын камераар тоноглогдсон. Худгийн байршлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн амьтны судалгаанд үндэслэн тогтоосон болно. Тус худаг нь гурван жилийн турш тасралтгүй ажиллаж тус ууланд нутагладаг зэрлэг амьтад болох аргаль, янгир, үнэг, хярс, туулай болон шувуудыг цаг уурын хатуу ширүүн ямар ч нөхцөлд ангаж цангах аюулаас хамгаалах чухал цэг болж байгааг худгийн ажиглалтын камерт үлдсэн дүрс илтгэн харуулж байна.

VIII. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Тайлант онд Нэгдсэн менежментийн тогтолцооны Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015, ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны ISO 45001-2018 стандартын хүрээнд Францын баталгаажуулалтын байгууллага "Афнор групп"-ын давтан магадлах аудитад хамрагдаж, сертификатуудыг хүлээн авсан.

 **100%**
(2021: 93%)

**Хяналт шалгалтын
үнэлгээнээс авсан дүн**



 **"0"**
(2021: 0%)

Эндэгдэл

 **"0"**
(2021: 0%)

**Мэргэжлээс
шалтгаалах өвчлөл**

 **6.9 сая**
(2021: 5.9 сая)

Ажилласан хүн/цаг

Энержи Ресурс компани нь эрхэм зорилго, үнэт зүйлсийг баримтлан, ажилтанд ээлтэй, эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, ажлаа аюул осолгүй гүйцэтгэх боломжийг ханган Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулдаг.

Бид холбогдох бүхий л үйл ажиллагаандаа олон улсын ISO 45001:2018 стандарт болон Монгол Улсын ХАБЭА-н тухай хуулийг чанд мөрдөн ажиллаж байна. ХАБЭА-н мэдээллийн санг ISO 45001:2018 стандартын бүтцийн дагуу бий болгож, дата мэдээллийг хуримтлуулан дүн шинжилгээ, тайлан мэдээг боловсруулан ажилладаг ба 2022 онд үйл ажиллагаа болон, мэдээллийн сангийн цахим системийг хөгжүүлэх замаар гүйцэтгэлийг сайжруулахаар зорьж байна.

Түүнчлэн ХАБЭА-н бодлогыг тасралтгүй сайжруулах, ослыг бууруулах, аюул эрсдлийн хяналтыг сайжруулах зорилгоор бүх журам гурван жил тутам хянагдаж, тасралтгүй шинэчлэгдэн, сайжирч явдаг.

ХАБЭА-н хэсэг нь компанийн бүх хэлтэс алба, туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөгөө өгч ажилладаг ба Ухаа худаг уурхай, Баруун наран уурхай, Гашуун сухайт авто зам, Ханбогд сумын Цагаан хад хэсэг, Ганц мод боомтын чингэлэг тээврийн терминалын хэсгүүдэд ХАБЭА-н өдөр тутмын хяналтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид Монголын уул уурхайн компаниудаас анх удаа Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартыг цогцоор нэвтрүүлж, олон улсын стандартын шаардлагыг хангасан компани болсон. Компанийн хэмжээнд осол бууруулах болон аюулгүй ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж, 2022 оны байдлаар 6.9 сая хүн/цаг ажиллан, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдолгүй ажиллаж байна.

Ажилтнууд манай компанийн амин чухал үнэт зүйл гэж бид үздэг тул хөдөлмөр эрхлэх орчинг нэн тэргүүнд анхаардаг. Бидний зорилго бол мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй сайжруулж, осол эндэгдэлгүй орчныг бүрдүүлэх явдал юм.

Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажиллагсдаа эрүүл, аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч бүх талуудын аюулгүй байдлыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн хангахыг эрмэлздэг.

Мөн уурхайн үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийт, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагд нэн тэргүүний ач холбогдол өгч "Аюулгүй эхэлж, аюулгүй дуусгая" уриаг эрхэмлэн ажиллаж мөрсөн.

ХАБЭА-Н ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2020	2021	2022
I.	Нийт ажилласан хүн цаг (сая)	9.1	5.9	6.9
II.	Эндэгдэл	2	0	0
III.	Нийт гэмтлийн давтамж	1.64	1.01	1.59
IV.	Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамж (LTIFR)	0.55	0.00	0.43
V.	Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	0	0	0
VI.	Хууль, журамд нийцэж ажилласан байдал	+90%	+93	+100%
VII.	ХАБ-ын сургалт, зааварчилгаа	12,900	7,850	12,150

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД

Нийт ажилтныг ажлын байрны сөрөг хүчин зүйлд өртөх, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх зорилгоор ХАБАЭ-н тухай хууль болон бусад хууль, эрх зүйн баримт бичиг, олон улсын конвенц, ISO 45001:2018 стандартын хэрэгжилтийг хангуулж ажилладаг. Үүнд:

- Ажлын байрнаас эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох бүхий л эрсдэлт хүчин зүйлсийг ижил өртөлтийн бүлэг тус бүрээр эрх бүхий байгууллагаар болон дотоодын хэмжилт, мониторингоор илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө боловсруулан ажиллах, тандах, хянах;
- Дотооддоо баталгаат багаж ашиглан нийт ажлын байранд сар бүр тоос, хувь хүний болон талбайн шуугиан, агаарын хэм, харьцангуй чийгшил, аммиак, хүхэрт ус төрөгч, угааарын хий, гарт дамжих доргионы хэмжилтийг хийж, хэмжилтийн үзүүлэлтийг MNS стандарттай харьцуулан, стандартын шаардлагад нийцэхгүй үзүүлэлтийг сайжруулах зөвлөмж бичиж,

- тайлан, мэдээг алба, хэсэг, нэгжийн удирдлагад хүргүүлж, гүйцэтгэлийн биелэлтийг хянах;
- Нийт ажилтанд ажлын байрны эрсдэлт хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч, сургалт орох, сургалтын материал бэлдэх;
- Нийт ажилтныг стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгслийг сонгоход санал, зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэх;
- Ажлын талбай дээр стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн түр амрах, дулаацах, сэрүүцэх, хооллох байр, цэвэр усаар хангах;
- Нийт ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах зэрэг ажлуудыг тус тус зохион байгуулдаг ба хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдлийн болон хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээний зөвлөмжийн гүйцэтгэл, дотоодын хэмжилтийн зөвлөмжийн гүйцэтгэл 80-90%-тай байна.


ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦТЭЙ БАЙДАЛ

Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний хүрээнд уурхайн бүх үйл ажиллагааг хамарсан төлөвлөгөөт дотоод хяналт шалгалтыг оны эхэнд давхардсан тоогоор 72 хяналтын чиглэлд хийхэд нийт 217 үл нийцэл илэрч, хууль сахин мөрдөлт 89%, эрсдэл үүсэх магадлал 10%-тай дүгнэгдсэн. Оны эцэст гүйцэтгэлийн шалгалт хийхэд 85 үл нийцэл бүрэн залруулагдаж, 132 үл нийцэл төлөвлөгөөний дагуу залруулалт хийгдэж байсан. Хууль сахин мөрдөлт оны эцэст 6%-иар сайжирсан буюу 95% болсон, эрсдэл үүсэх магадлал 5%-иар буурч сайжирсан үзүүлэлт гарсан байна.

Тайлант онд Монгол Улсын Засгийн Газраас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааг түр зогсоосон тул энэ чиглэлийн хяналт шалгалтууд хийгдээгүй. Харин төрийн эрх бүхий дараахь

байгууллагууд хяналт шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт өгсөн байна.

- Өмнөговь аймгийн Тагнуулын газраас тэсрэх материалын ашиглалт, Өмнөговь аймгийн ЗДТГ-аас усны ашиглалт, Ашигт малтмал газрын тосны газраас Нүүрс баяжуулах үйлдвэр, төмөр замын шинэ терминалын үйл ажиллагааны чиглэлээр тус тус хяналт хийсэн бөгөөд эдгээр шалгалтуудаар ямар нэг зөрчил илрээгүй.
- Өмнөговь аймгийн ОБГ-аас Шатахуун түгээх станц дээр галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт шалгалт хийж, эрсдлийн түвшинг “бага” гэж үнэлсэн ба хяналтын үед илэрсэн зургаан зөрчлийг залруулах зөвлөмж өгсөн. Зөвлөмжийг хуулийн хугацаанд нь бүрэн залруулж албан тоотоор хариуг хүргэж танилцуулсан.



СУРГАЛТ ЗААВАРЧИЛГАА

Монгол Улсын хууль тогтоомж, төрийн захиргааны байгууллагын баталсан дүрэм журмын хүрээнд ХАБЭА-н сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Уурхайн сургалтын төв нь 9 төрлийн ХАБЭА сургалт зохион байгуулах эрхтэй бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн менежмент, өндөр эрсдэлтэй ажлын байр, мэргэжлээс шалгаалах өвчин, анхны тусламж, эрүүл мэнд, хамгаалах хэрэгсэл, цахилгааны аюулгүй байдал, анхны тусламж гэх мэт 24 төрлийн сургалтыг тогтмол зохион байгуулан ХАБЭА-н соёлыг ажилтнууддаа түгээж байна.

Тайлант хугацаанд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид болон зочид төлөөлөгч 12,150 хүнд ХАБЭА-н мэдлэг, ур чадвар олгох 60,711 хүн/цагийн сургалт зааварчилгаа зохион байгуулсан байна. ХАБЭА-н чиглэлээр сургалтын хөтөлбөр, сургагч нарын мэргэжил ур чадварыг хөгжүүлэхэд компанийн зүгээс бүхий л нөөц боломжоор ханган, олон улсын болон дотоодын тэргүүн туршлагыг тухай бүр нэвтрүүлэн ажилласан байна.



ОНЦГОЙ БАЙДЛЫН БҮСИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Гамшгаас урьдчилан сэргийлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн ОБГ, Цогтцэций сумын ОБХ-тэй хамтарч Гамшгаас урьдчилан сэргийлэх команд штабын сургалт гурван удаа зохион байгуулахад хамтарч оролцжээ. Мөн онцгой нөхцөл байдал үүссэн үед онцгой байдлын бүсэд тусламж үйлчилгээ үзүүлэн хамтран ажилласаар ирсэн. Цогтцэций сумын ОБХ-ийн гал түймэр унтраах 44-р анги болон компанийн Аврах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор хамтарсан дадлага, сургалт хийж туршлага солилцон ажилладаг. Сумын хэмжээнд гарсан гал түймэр, осол аваар, байгалийн аюулт үзэгдлээс хүний амь нас, байгууллага, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг аврах хамгаалахад тухай бүр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа. Онцгой байдлын нэгжийн бие бүрэлдэхүүн өөрсдийн бэлтгэл бэлэн байдлыг гурван үе шаттайгаар буюу бие бялдрын бэлэн байдал, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдал, аврах гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдал хангаж ажиллалаа.

Усчин аврагчийн сургалт

Усчин аврагчийн анхан шатны дадлага олгох төлбөрт сургалтыг анх удаа Өмнөговь аймгийн ОБГ болон БТСГ-тай хамтарч зохион байгуулж, нийт бие бүрэлдэхүүнийг хамрууллаа. Орон нутгаас ирүүлсэн гамшиг, осол аваар, аюулт үзэгдлийн таван дуудлагын дагуу ажиллаж, хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгааллаа.

Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийн дагуу заавал хөтлөгдөх бичиг баримтыг хууль дүрэм, журам, заавар, загварын дагуу боловсруулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд галын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай дотоодын болон олон улсад дагаж мөрдөж буй стандарт, норм дүрмийг удирдлага болгон ажиллаж байгаа бөгөөд галаас хамгаалах системийн найдвартай ажиллагааг хангахад илүү анхаарч ажилласан жил болсон.

IX. ШАГНАЛ

2022 онд Энержи Ресурс компанийн хувьд улс орны эдийн засагт бодитой хувь нэмэр оруулж, томоохон татвар төлөгч, ажил олгогчийн байр сууриа хадгалсныг төрийн ба холбогдох байгууллагуудаас өндрөөр үнэлж, талархал хүлээлээ. Тус компани нь сүүлийн арав гаруй жилийн турш тасралтгүй Монгол Улсын “ТОП-100 ажуйн нэгж”, “Оны онцлох 10 аж ахуйн нэгж”, “Шилдэг татвар төлөгч 10 аж ахуйн нэгж” гэсэн шалгаруултанд тэргүүлэх байр сууриа хадгалж ирлээ.

Компанийн нийгмийн хариуцлагын бодлого,
Соёлын өвийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн
Сентрал тв | Энержи Ресурс
“Монгол өв соёл” нэвтрүүлгийн бүтээлүүдээс...



ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖИЙН ШАЛГАРУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим хамтран нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй “ТОП-100 аж ахуйн нэгж”-ийг эрэмбэлж, өргөмжлөх үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай.

2010	IV байр	2018	V байр
2011	III байр	2019	V байр
2012	IV байр	2020	V байр
2013	IV байр	2021	X байр
2017	V байр	2022	III байр



ЭНТРЕПЕНЁР 2022- ОНЫ ОНЦЛОХ 10 АЖ АХУЙН НЭГЖ

Бизнесийн салбарт өндөр амжилт гаргаж, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй онцлох ААН, байгууллага, бизнес эрхлэгчдийг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас жил бүр шалгаруулж, тодруулсаар ирсэн.

2010	Гранпри шагнал	2018	X байр
2011	IX байр	2019	Мөнгөн меркури
2012	VII байр	2021	Хүрэл меркури
2013	VIII байр	2021	Мөнгөн меркури
2017	VI байр		



ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ 10 АЖ АХУЙН НЭГЖ

Жил бүрийн 5-р сард Татвар төлөгчдийн өдрөөр Татварын ерөнхий газраас шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг шалгаруулдаг. Сангийн яам ба Татварын ерөнхий газраас хамтран тодруулдаг уг шалгаруулалтад татварын нэгдсэн дүнгээс гадна татвар төлөгчдийн хариуцлагатай, үлгэр жишээч байдлыг гол шалгуур болгон авч үздэг байна.

2011	V байр	2019	VII байр
2012	I байр	2020	V байр
2013	V байр	2021	VII байр
2014	V байр	2022	IV байр
2018	VII байр		



Компанийн нийгмийн хариуцлагын бодлого,
Соёлын өвийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн
Сентрал тв | Энержи Ресурс
“Монгол өв соёл” нэвтрүүлгийн бүтээлүүдээс...

Сэнтрал Тауэр 16 давхар, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14200, Монгол Улс

www.energyresources.mn

Галерей кэмп, Цогтцэций сум, Өмнөговь аймаг
46040, Монгол Улс

Утас: 976 7012 2279
Факс: 976 11 322 279

